

**ҮАГ**

**Үндэсний аудитын газрын 2005 оны  
бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний  
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн  
аудитын тайлан**

---

2005 оны 6 дугаар сар

**Зардлын гүйцэтгэл, үр дүнгийн  
хяналт, тайлагнал хангалтгүй  
байна**

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй  
эрсдэлийг нөхөх зардал, төсвийн  
хуваарилагдаагүй зардлын 2004 оны гүйцэтгэл

Улаанбаатар хот

---

## Агуулга

---

<b>Ерөнхий зүйл</b>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	2
	Аудитад ашигласан шалгуур	3
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	3
<b>Аудитын дүн</b>	Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын төлөвлөлт, хуваарилалт	5
	Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг тайлагнасан байдал	8
	Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт	11
<b>Дүгнэлт</b>		13
<b>Холбогдох байгууллагын санал</b>	Сангийн яамны санал	14
<b>Зөвлөмж</b>		15
<b>Хавсралт</b>	Хавсралт	16

Товчилсон үг

- УИХ – Улсын Их Хурал
- СЭЗЯ – Санхүү, эдийн засгийн яам
- СЭЗС – Санхүү, эдийн засгийн сайд
- БСШУЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
- ЗГНС – Засгийн газрын нөөц сан
- БЭНЗ – Болзошгүй эрсдэлийг нөхөх зардал
- ТХЗ – Төсвийн хуваарилагдаагүй зардал

---

## Ерөнхий зүйл

---

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2004 оны зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийв.

Дээрх зардлын гүйцэтгэл, үр дүнг шалгаж дүгнэлт гарган, зөрчил дутагдал илэрвэл түүнийг арилгах санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараахь дэд зорилтыг дэвшүүлж ажиллалаа. Үүнд:

- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын төлөвлөлт, хуваарилалт;
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг тайлагнасан байдал;
- Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.

Сангийн яам, Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч зарим байгууллагуудын холбогдох баримт материалд үндэслэн Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын журам, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэв.

Аудитад ашигласан шалгуур

Дэвшүүлсэн зорилтуудтай уялдуулан дараахь шалгуурыг аудитад ашиглав.

- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 13.2-т “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалт;
- Тайлант хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг СЭЗС-ын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам”-ын 2 дугаар бүлэгт заасны дагуу түүнд нөлөөлөх хүчин

---

## Ерөнхий зүйл

---

зүйлсийг харгалзан оновчтой төлөвлөсөн эсэх;

- Дээрх журмын 3 дугаар бүлэгт дурдсаны дагуу Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын зориулалтыг зардлын эх үүсвэр болон зүйл тус бүрээр тодорхой заасан эсэх;
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- Дээрх зардлын эх үүсвэрээс хөрөнгө олгох, гүйцэтгэлийг хэрхэн тооцохыг заасан журмын 5 дугаар бүлэг;
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгохдоо тендерийн холбогдолтой хууль тогтоомжийг баримталсан эсэх;
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр 2004 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг түүнийг хэрэгжүүлэхээр гарсан холбогдох тогтоол шийдвэрүүдтэй харьцуулан шалгах;
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2002, 2003 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2003 оны 67, 2004 оны 59 дүгээр тушаалуудыг үндэслэн Санхүү, эдийн засгийн сайдад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.

Аудитын  
стандартын  
талаархи  
мэдэгдэл

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандартын дагуу холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, тайлбар, нотолгоо авах, орлого, зарлагыг анхан шатны баримтаар түүвэрлэн шалгах, тулган баталгаажуулах, төсөвт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан хийлээ.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, судалгаа, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга, тэргүүлэх аудитор Д.Ганбилэг

---

## Ерөнхий зүйл

---

удирдаж, тус хэлтсийн Төсөв, санхүү, банк, өр, зээлийн багийн аудиторууд 2005 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 6 сарын 1-нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

---

## Аудитын дүн

---

ЗГНС болон  
БЭНЗ, ТХЗ-ын  
төлөвлөлт,  
хуваарилалт

2004 оны төсвийн тухай хуулиар Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардалд нийт 10544.3 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дотор Засгийн газрын нөөц санд 4000,0 сая, болзошгүй эрсдэлийг нөхөх зардалд 4513.4 сая, улсын төсвийн хуваарилагдаагүй зардалд 2030,9 сая төгрөг тус тус хуваарилжээ.

Засгийн газрын нөөц сангаас 58 төсөл, арга хэмжээнд 4357,4 сая, улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас 42 төсөл, арга хэмжээнд 1527.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсөл, арга хэмжээ тус бүрт холбогдох шийдвэрүүд гарсны гадна болзошгүй эрсдэлийг нөхөх зардлаас Дорноговь аймгийн зарим сумдын нутагт малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан 460,5 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

СЭЗС-ын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам”-ын 2 дугаар бүлэгт Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг төлөвлөх, хуваарилахад харгалзаж үзэх шалгуур үзүүлэлтүүд болон зардлын нийт хэмжээг тогтооход ямар зарчим баримтлахыг тодорхойлжээ.

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2002 - 2004 оны гүйцэтгэлийн тайлангаас харахад эдгээр зардлыг сүүлийн 3 жилд ижил хэмжээгээр төлөвлөн, батлуулж байсны гадна 2002 онд 336.4 сая, 2003 онд 334.9 сая, 2004 онд 513.3 сая төгрөг хэмнэсэн байна.

Дээрх зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг ус цаг уурын байгууллага, байгалийн гамшигтай холбогдсон урьдчилсан төсөөлөл гаргах эрх бүхий байгууллагуудын мэдээлэл, судалгаа, сүүлийн жилүүдийн бараа, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, цаашдын төсөөлөл зэрэг хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан бодитой төлөвлөөгүй байна.

Энэ нь Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх үйл ажиллагаанд шаардагдах мэдээлэл, түүнийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, хянах эрх зүйн болон хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болоогүй, энэ талаар гарсан тушаал шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтнууд мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гол зардал болох улс орны болон бүс нутгийн чанартай байгалийн гамшиг, нийтийг хамарсан аюул бүхий гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах, таслан зогсоох, эмчлэх чиглэлээр авч байгаа арга хэмжээ, үйлдвэрлэлийн ноцтой осол гарсантай холбогдож гарсан шууд зардал, хохирсон хүмүүст олгох тэтгэмж, тусламж, үр дагаврыг арилгах чиглэлээр санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлэх арга хэмжээнд 2004 онд 502.5 сая төгрөг зарцуулахаар холбогдох шийдвэр гарчээ.

Энэ нь Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 2004 онд зарцуулахаар шийдвэрлэсэн нийт хөрөнгийн 11 хувийг эзэлж байна.

Дээрх хөрөнгийн 25 хувь буюу 1086.0 сая төгрөгийг улсын төсөвт нэг бүрчлэн тооцож тусгах боломжгүй, цаг үеийн нөхцөл байдлын улмаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуудлуудыг шийдвэрлэхэд, 64 хувь буюу 2812.3 сая төгрөгийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон бусад арга хэмжээнд тус тус зарцуулах шийдвэр гарчээ.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэрээр 2004 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн төсөл арга хэмжээний жагсаалтыг холбогдох шийдвэр тус бүрээр хавсралт № 1-д үзүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулсан хөрөнгийн 58 хувийг байгууллага, иргэдээс санхүүгийн дэмжлэг, тусламж хүссэн хүсэлтийн дагуу авсан арга хэмжээнд, 10 хувийг Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн болон төрийн албан хаагч нэр бүхий 9 хүний гадаад, дотоодод эмчлүүлэх зардалд, 17 хувийг гадаад, дотоодын төлөөлөгчдийг хүлээн авахтай холбогдсон зардалд, 15 хувийг олон улсын болон орон нутгийн чанартай урлаг, спортын төрөл бүрийн тэмцээн, наадам, тэмдэглэлт ойн арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зардал тус тус эзэлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд нийт 1980.9 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсний дотор орон нутгийн театр, чуулгыг хөгжим, дуу чимээний техник хэрэгсэл болон кино проектороор хангах талаар БСШУЯ, СЭЗЯ, “Буян” ХХК-ын хооронд байгуулсан гэрээний дагуу хийсэн санхүүжилтэд 66 хувийг, эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй аймгуудын эрчим хүчний үйлдвэрийн найдвартай ажиллагааг сайжруулах, өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор, дизелийн түлшний үнийн өсөлтөөс үүссэн алдагдлыг нөхөхөд зориулж олгосон санхүүжилтэд 16 хувийг, Ирак дахь дайны дараах гамшигийг арилгах, сэргээн босгох, энхийг сахиулах хүмүүнлэгийн олон улсын ажиллагаанд оролцох 3 дугаар ээлжийн цэргийн багийн

томилолт, гэнэтийн ослын даатгал, бусад хангалтад шаардагдах хөрөнгийн санхүүжилтэд 6 хувийг, бусад арга хэмжээнд үлдэх 12 хувийг тус тус зарцуулахаар шийдвэрлэжээ.

Улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг хэрхэн хуваарилж шийдвэрлэсэн байдлыг “Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам”-ын 3 дугаар зүйлийн Б-д заасан зардлын зориулалттай харьцуулсан судалгааг хавсралт № 2-т үзүүлэв.

Дээрх судалгаанаас үзэхэд улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн нийт хөрөнгийн 24 хувь буюу 412.9 сая төгрөгийг тогтоосон зориулалтын дагуу (Монгол банк болон арилжааны банк, бусад байгууллага, төсвийн гүйцэтгэл хангахтай холбогдсон Засгийн газрын үйлчилгээ үзүүлсний хөлс, төсвийн жилийн дундуур шинээр батлагдсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын тогтоолын дагуу тухайн жилд гарах нэмэгдэл зардал, төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаатай хамааралтайгаар хууль хяналтын эрх бүхий байгууллагаас төвлөрсөн төсвөөс нөхөн төлбөр хийлгэхээр гаргасан төлбөрийн санхүүжилт), 76 хувь буюу 1302.9 сая төгрөгийг тогтоосон зориулалтаас өөр зүйлд зарцуулахаар шийдвэрлэжээ.

Зориулалт бусаар зарцуулахаар шийдвэрлэсэн нийт хөрөнгийн 13 хувь буюу 169.2 сая төгрөгийг сонин, мэдээлэл түгээх болон сурталчилгааны ажилд, 8 хувь буюу 103.7 сая төгрөгийг гадаад дотоодын зочин төлөөлөгчдийг хүлээн авах, айлчлалын зардалд, 79 хувь буюу 1019.0 сая төгрөгийг бусад арга хэмжээнд зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр 2004 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн дийлэнх хувийг “Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам”-д заасан зориулалтаас өөр зүйлд зарцуулжээ.

Энэ нь Засгийн газрын нөөц сан, хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд дээрх журмыг биелүүлэх, энэ талын харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санаачлага муутай ажилласнаас шалтгаалжээ.

Тодорхой төлөвлөж тухайн жилийн төсвийн төсөлд тусган



санхүүжүүлэх боломжтой зарим зардлыг дээрх хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа нь энэ эх үүсвэрийн утга агуулга, зорилго, хөрөнгө хуваарилах, санхүүжүүлэх зарчмыг алдагдуулахад хүргэж байна.

ЗГНС болон БЭНЗ, ТХЗ-аас санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг тайлагнасан байдал

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлыг 2004 онд ямар зориулалтаар хэрхэн хуваарилж зарцуулсан байдлыг зардлын эх үүсвэр болон зүйл тус бүрээр хавсралт №1, 2-т үзүүлэв.

Тайлант хугацаанд Засгийн газрын нөөц сангаас 3990.4 сая, болзошгүй эрсдэлийг нөхөх зардлаас 443.4 сая, төсвийн хуваарилагдаагүй зардлаас 1527.2 сая төгрөг тус тус зарцуулжээ.

“Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам”-д Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрхэн санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, хянах талаар дараахь зохицуулалтуудыг хийж баталгаажуулжээ. Үүнд:

- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардалд төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалтад урьдчилсан хяналт, санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх, гүйцэтгэлийн мэдээг тайлагнах үүргийг Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газарт (хуучин нэрээр) даалгажээ;
- Холбогдох шийдвэрийг үндэслэн тухайн төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэх байгууллага нь уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөв болон холбогдох тооцоог тус газарт ирүүлж хянуулах;
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд зориулан олгосон зардлын тайланг хариуцан гүйцэтгэсэн байгууллага нь уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа 15 хоногийн дотор гүйцэтгэлийг тайлагнах;
- Зардлын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан байхаас гадна үндсэн баримтын нэг хувийг хавсаргах;
- Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газар дээр

дурдсан төлөвлөгөө, төсөв болон холбогдох тооцоог хүлээн авч гүйцэтгэгч нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлан, төсвийн үнэлгээ нь тухайн үеийн зах зээлийн үнэ ханштай нийцэж байгаа эсэхийг нарийвчлан хянаж, санхүүжилтийг олгож байх.

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлийг хэрхэн тайлагнасан талаархи судалгааг хавсралт № 1, 2-д үзүүлэв.

Судалгаанаас харахад тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байгууллагууд Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлаас зарцуулсан 5961.0 сая төгрөгийн 16 хувь болох 951.9 сая төгрөгийн зарцуулалтыг тайлагнасан баримт материал огт байхгүй, 15.6 хувь болох 929.2 сая төгрөгийн зарцуулалтыг бүрэн хэмжээгээр тайлагнаагүй байна.

Өөрөөр хэлбэл тухайн төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа яам, агентлаг, бусад байгууллага түүнд зориулан олгосон зардлын гүйцэтгэлийн тайланг тогтоосон хугацаанд холбогдох газарт тайлагнаагүй байна.

Болзошгүй эрсдэлийг нөхөх зардлаас малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан 443.4 сая төгрөг зарцуулсан боловч түүний гүйцэтгэл, үр дүнгийн талаархи анхан шатны баримт материалыг холбогдох байгууллага нь ирүүлээгүй байна.

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, хянах үйл ажиллагаа дээр дурдсан шаардлагын хэмжээнд хийгдээгүй байна.

Сангийн яамны Төрийн сангийн газар тухайн төсөл, арга хэмжээний төсөв төлөвлөгөөг тухай бүр хянаж, санхүүжилтийг олгож байгаагүйгээс ихээхэн хэмжээний төсвийн хөрөнгө хэрхэн юунд зарцуулсан талаархи баримт материалгүйгээр зарлага болсон байна.

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө хэрхэн зарцуулагдаж, ямар үр дүнд хүрсэн эсэхийг шалгаж дүгнэлт өгөхөд хүндрэл учруулж байв.

Аудитын явцад тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зарим байгууллагаар зардлын гүйцэтгэл, үр дүнгийн тайлан, материалыг

холбогдох байгууллагаас нь гаргууллаа. Тухайлбал:

- Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс УИХ-ын дарга С.Төмөр-Очир, УИХ-ын гишүүн С.Төмөр, Д.Алтай, Д.Одхүү, Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын дэд дарга Л.Ганбаатар, Улсын нөөцийн газрын дарга Ж.Бямбаноров нарын гадаад дотоодод өөрийн биеийг эмчлүүлэх зардалд авсан хөрөнгийн зарцуулалт (Мөнгө авах үеийн албан тушаалаар бичив);
- Япон улсын "Марубени Хонг-Конг" компаний нэхэмжлэлтэй холбоотой хэрэгт Монгол Улсын Засгийн газрын хуулийн зөвлөхөөр ажиллаж байгаа Английн "Ричардс Батлер" компаний өмгөөллийн хөлс болон бусад зардалд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, үр дүн;
- Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх 31.5 сая төгрөгийн зарцуулалт, үр дүн;
- Орон нутгийн театр, чуулгын дуу, гэрлийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардагдах 1279.3 сая төгрөгийн гүйцэтгэл, үр дүн (Техник тоног төрөөрөмжийг "Буян" ХХК захиалагч болон санхүүжүүлэгч байгууллагын ямар нэг хяналтгүйгээр сумдад өөрсдөө тараасан байна).

Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарын эмчилгээний зардлын гүйцэтгэл, тайланг холбогдох байгууллага нь гаргаж өгөөгүй байна.

Ардчилал, хүний эрхийн өдрийг тэмдэглэх арга хэмжээний зардалд зориулж олгосон 29.5 сая төгрөгийг Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дансанд төвлөрүүлэн зарцуулах ёстой байсан боловч Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Ш.Түвдэндоржийн зөвшөөрлөөр Монголын Ардчилсан холбооны дансанд шилжүүлүүлэн зарцуулсан нь хяналт тавихад бэрхшээлтэй болгожээ.

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс тендер зарлалгүй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний талаархи судалгааг хавсралт № 1,2-т үзүүлэв.

Засгийн газрын 2004 оны 109, 174 дүгээр тогтоолоор орон нутгийн театр, чуулгын дуу, гэрлийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх 2 үе шатны төсөл хэрэгжүүлэхэд Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, "Буян" ХХК-ны хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу Засгийн газрын нөөц сангаас 1279.3 сая төгрөг зарцуулсан нь тус сангаас 2004 онд зарцуулсан нийт хөрөнгийн 32 хувийг эзэлж байна.

---

## Аудитын дүн

---

Энэ ажлын гүйцэтгэгчийг сонгохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу тендер зарлаагүй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны талаархи мэдээллийг сум, баг, хорооны Засаг дарга нарт хүргэх зорилгоор тэдэнд сонин захиалах, хүргэх ажилд нийт 159.7 сая зарцуулсан байна. Энэ ажлын гүйцэтгэгчийг тендер зарлалгүй сонгож, “Үнэн”, “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”-г захиалахаар тухайн байгууллагуудтай шууд гэрээ байгуулжээ.

Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 2002 оны гүйцэтгэл, үр дүнд 2003 оны 5 дугаар сард, 2003 оны гүйцэтгэл, үр дүнд 2004 оны 6 дугаар сард тус тус гүйцэтгэлийн аудит хийжээ.

Дээрх гүйцэтгэлийн аудитын тайлан, түүнд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий аудитор 2003 оны 67, 2004 оны 59 дүгээр тушаалаар баталгаажуулж, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2003 оны 12 дугаар сарын 15 болон 2004 оны 12 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт тус тус танилцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвлөсөн байна.

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2002, 2003 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлтийг Сангийн яам хэрхэн гаргаж ирүүлсэн талаархи судалгааг хавсралт № 3-д зөвлөмж тус бүрээр үзүүлэв.

Сангийн яам Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2002 оны гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлтийг тогтоосон хугацаанаас 5 сараар хоцроож ирүүлсэн байна.

СЭЗЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатарын гарын үсэгтэй 2004 оны 5-7<sup>а</sup>/2002 дугаар албан бичгээр Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2002 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлжээ.

Дээрх албан бичигт Засгийн газрын нөөц сан болон болзошгүй

эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж хөрөнгийг олгохдоо зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавьж, урьдчилгаа олгох замаар гүйцэтгэлээр санхүүжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байгаа болон Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг хуульчлахаар төслийг боловсруулан, яамдаас санал авч Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн талаар дурджээ.

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2003 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн биелэлтийг 2004 оны 12 дугаар сарын 29-нд ирүүлжээ.

Энд Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ урьдчилгаа олгох замаар гүйцэтгэлээр санхүүжүүлэх, зарцуулагдаагүй хэмнэгдсэн хөрөнгийг төсөвт эргүүлэн татах зарчмыг баримталж ажилласан болон хуулийн төслийг дахин өргөн барихаар болсон тухай дурджээ.

Дээрх судалгаа болон өмнө хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүн, дүгнэлт, энэхүү аудитын явцад олж цуглуулсан нотлох баримт, бусад материалаас харахад өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдлууд жил дараалан давтагдаж байгаа нь холбогдох байгууллага, албан тушаалтнууд аудитын удаа дараагийн зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж, бодитой үр дүнд хүрээгүй байна.

---

## Дүгнэлт

---

Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2004 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материалд хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бодитой төлөвлөөгүй байна.
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр 2004 хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн дийлэнх хувийг холбогдох журамд заасан зориулалтаас өөр зүйлд зарцуулахаар шийдвэрлэжээ.
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлаас зарцуулсан хөрөнгийн санхүүжилтийг хянах, түүний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Сангийн яам Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэл, үр дүнд өмнө хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулж, санаачлагатай ажиллаагүй байна.
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

## Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

21060 Улаанбаатар хот, Төвдөмөр дүүрэг,  
Найдсан үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: 32 62-47, E-mail: altankhaagad\_a@oorg.mn  
http://www.maf.gov.mn


2005.6.14 № 5-АА/2015  
таниай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Санал өгөх тухай

Засгийн газрын нөөц сан болон бэлэвэшгүй эрсдлийг нөхөх зардал, төсвийн хуваарилдаагүй зардлын гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангай танилцлаа.

Аудитын дүгнэлт, зөвлөмжийн 2-т "2004 онд Засгийн газрын нөөц сан болон бэлэвэшгүй эрсдлийг нөхөх зардал, төсвийн хуваарилдаагүй зардлаас зарцуулсан нийт хөрөнгийн 70 хувийг хяналтгүй зарцуулжээ" гэсэн байна. Нийт 2004 онд зарцуулагдсан хөрөнгийн 13,0 хувь буюу 506,4 сая төгрөгийн гүйцэтгэлийн баримтыг бүрдүүлээгүй байна.

Цаашдаа бид аудитын санал, зөвлөмжийн дагуу "Засгийн газрын нөөц сан болон бэлэвэшгүй эрсдлийг нөхөх зардал, төсвийн хуваарилдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам"-ыг хуульчлан батлуулах болон гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээг авч, шат дараалан хэрэгжүүлэх болно.



ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

*Ч.Хүрэлбаатар*

Ч.ХҮРЭЛБААТАР

08 1642

---

## Зөвлөмж

---

Энэхүү аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Н.Алтанхуягт зөвлөж байна.

- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, бүрдүүлэх, захиран зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах үйл явцыг хуульчлах асуудлыг боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
- Дээрх асуудлыг зохицуулсан хууль гарах хүртлэх хугацаанд Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах заавар гаргаж мөрдүүлэх.
- Дээрх эх үүсвэрээс олгосон зардлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнаагүй, түүнд хяналт тавих албан үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтантай тухай бүр хариуцлага тооцож байх.
- Аудитын явцад өгөгдсөн зөвлөмжийн биелэлт, үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд албан ёсоор хариу ирүүлж байх.

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

НЭГДҮГЭЭР ХЭЛТСИЙН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ГАНБИЛЭГ